

ЯДУУРАЛ, ТЭГШ БУС БАЙДАЛ – ДЭЛХИЙ НИЙТИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Д.Намсрай*, Д.Отгончимэг**

Хүн төрөлхтөн Ядуурлыг бууруулах олон улсын өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 17-ны өдөр тэмдэглэн энэ талбарт олсон ололт амжилтаа нэгтгэн дүгнэдэг уламжлалтай. Энэ онд энэ тэмдэглэлт өдөртэй давхцан манай улсад “2005 оны Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-ийн албан ёсны нээлт боллоо. 2005 оны Дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь өнөөгийн эрх тэгш бус ертөнцөд хүний хөгжлийн түвшинг тодорхойлоход чухал ач холбогдолтой чиглэлийг тусламж, худалдаа, аюулгүй байдал хэмээн дүгнээд эдгээр салбарын хөгжилд анхаарлаа хандуулахыг улс орнуудад уриалсан байна. Энэхүү илтгэлд дурьдсанаар 1990 онд 28 хувь байсан туйлын ядуурал 2005 онд 21 хувь болон буурч, 130 сая хүн ядуурлаас салж чадсан зэрэг амжилт дэвшил гарч байгаа хэдий ч энэ нь улс орон бүрт, улс орны дотор, бүс нутаг бүрт харилцан адилгүй, тэгш бус байна. Өнөөдөр дэлхий дээр 800 сая гаруй хүн өлсгөлөн, хоол тэжээлийн хомсдолд нэрвэгдэж, өдөр бүр 30000 хүүхэд ядуурлын улмаас эндэж байна. Ядуурлыг бууруулах олон улсын өдөрт зориулсан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи А.Аннаны илгээлт захидалд “...бид ядуу хүмүүс, тэр тусмаа туйлын ядуу, ялангуяа хөгжлийн үйл явцаас ихэнх тохиолдолд завсардан хоцордог тэр л хүмүүст хүрч чадсан цагт ядуурлыг бууруулж чадна... Гагцхүү тэдэнтэй түншилж, аливаа тэгш бус үзэгдлийг устгахын төлөө хамтдаа тэмцэж байж гэмээнэ бид ядуурлын бүх хэлбэрийг сая устгаж чадах билээ” гэж дурдсан байна.

Монгол улс хүний хөгжлийн индексээр (0,679) 177 орноос 114-т орж байгаа нь тун чамлалттай үзүүлэлт юм. Гадаад болон дотоод нөхцөл байдал тайван, хүн ам нь бичиг үсэг бараг бүрэн тайлагдсан, мэдлэг боловсролтой, улс орон нь байгалийн үлэмж баялагтай, олон улсын дэмжлэг тусламжийг чамлахааргүй авч байгаа улсын хувьд бид хүний хөгжлийн түвшингээр хавьгүй

* МУИС-ийн ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

** МУИС-ийн ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

дээгүүр явах бүрэн боломжтой билээ. Гол учир шалтгаан нь хүний хөгжлийн гурван шалгуурын нэг болох амьжиргааны түвшин ерөнхийдөө доогуур, өөрөөр хэлбэл ядуурлын түвшин өндөр хэвээр, түүнийг бууруулж чадахгүй байгаатай шууд холбоотой юм. 2004 оны байдлаар Монгол улсын хүн амын 36.3 хувь нь ядуу¹, хүн амын ядуурлын индексээр дэлхийн улсуудын 44-т, нийгмийн орлогын (баялаг) 69.7 хувь нь тэгш бус хуваарилагддаг, хүн амын 27.0 хувь нь өдрийн нэг ам. доллараас доогуур орлоготой² байна.

Тэгш бус байдлын нэг тод илрэл бол хот, хөдөөгийн хүмүүсийн хөгжлийн ялгаатай байдал юм. Монголын хүний хөгжлийн энэхүү тулгамдсан асуудлыг “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-т авч үзэж судалгааны үр дүн, зөвлөмжүүдийг дэвшүүлсэн байна.

2002 оны байдлаар хотын хүний хөгжил хөдөөгийнхөөс 14.0 хувиар өндөр байгаа нь хот хөдөөд хүний хөгжлийн түвшин харилцан адилгүй байгааг илэрхийлж байна³.

2003 оны Монголын хүний хөгжлийн илтгэлийн нэг давуу тал бол хүний хөгжлийн индексийг аймаг хотоор тодорхойлж эрэмбэлүүлсэн явдал юм. Хүний хөгжлийн түвшин аймаг, хотоор мөн ялгаатай байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүний хөгжлийн түвшин, аймаг, хотоор, 2002

Ангилал	Монгол улсын ХХИ-ийн түвшин	Аймаг, хот
Хүний хөгжлийн доод бүлэг	0.630 хүртэл	Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Увс, Хөвсгөл
Хүний хөгжлийн дунд бүлэг	0.631-0.700	Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Ховд, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дархан-Уул, Говьсүмбэр
Хүний хөгжлийн дээд бүлэг	0.701, түүнээс дээш	Улаанбаатар, Орхон

Эх сурвалж: Монгол улсын 2003 оны Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, УСГ

1990 оноос хойш НҮБХХ хүний хөгжлийн сэдвээр нийтдээ 570 илтгэл гаргаад байгаа бөгөөд түүнээс 16 нь дэлхийн, 28 нь бүс нутгийн, 526 нь 120 гаруй

¹ Human development report 2005, UNDP

² Key indicators 2003, ADB

³ Монголын хүний хөгжлийн илтгэл 2003. Хот хөдөөгийн ялгаатай байдал

орны үндэсний илтгэлүүд юм. Монгол улсын хэмжээнд энэ илтгэл 3 удаа 1997, 2000, 2003 онд гарсан билээ. Эдгээр илтгэлүүд нь НҮБ, НҮБХХ, улс орны Засгийн газрын байр суурийг илэрхийлдэггүй, бие даасан судлаачид боловсруулдгаараа онцлогтой. Нөгөөтэйгүүр хөндөж буй асуудлаар илтгэлд орсон санал зөвлөмжийг засгийн газрууд заавал дагаж мөрдөх, хэрэгжүүлэх албагүй байдаг сул талтай. Хэдий тийм боловч хүний хөгжлийн илтгэлүүд нь маш чухал судалгаа болж, орчин үеийн амин чухал асуудлуудыг хөндөж, чухал санаа дэвшүүлж, өргөн олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татдаг. Хот хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдлаар бичигдсэн 2003 оны манай үндэсний хүний хөгжлийн илтгэл нь зон олны сэтгэлийг эмзэглүүлсэн нэн чухал тулгамдсан асуудлыг хөндөж чадсан нь Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд 2004 онд зохион байгуулсан “Хүний хөгжлийн илтгэл 2003. Хот хөдөөгийн ялгаатай байдал” илтгэлийн гол санаа, агуулга, зөвлөмжийг олон нийтэд сурталчлах ажлын үр дүн нотолж байна.

Сурталчилгааны ажил нь үндсэн гурван зорилготой байлаа. Үүнд:

- Дэлхийн болон хүний хөгжлийн илтгэл, тэдгээрийн ач холбогдол, хүний хөгжлийн концепцийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний ойлголт мэдлэгийг дээшлүүлэх;
- Хот хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдлын шалтгаанууд, нөлөөлж буй хүчин зүйлүүд болон зөвлөмжүүдийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, идэвх сонирхлыг бий болгох, дээшлүүлэх;
- Сурталчилгаа, судалгааны ажлын үр дүнг нэгтгэн олон нийтийн санал бодлыг бодлого боловсруулагчдад хүргэхэд оршиж байлаа.

Энэхүү ажлыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө сурталчилгаанд ашиглах “багц” материалыг урьдчилан бэлтгэж сурталчилгааны явцад ашиглан олон нийтэд танилцуулан түгээж байсан нь олон нийтийн анхаарлыг хэлэлцэж буй асуудалд төвлөрүүлэн санал бодлыг нь авахад их тустай болсон юм. Тухайлбал “Монголын хүний хөгжил 2003” баримтат кино, “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-ын хураангуй товхимол, олон нийт, хүүхдүүдэд зориулсан танилцуулга, орон нутагт зохион байгуулах сургалт семинарын илтгэлүүд, яриа таниулгын сэдвүүд,

санал асуулга, судалгаа, үнэлгээний маягтууд зэргийг урьдчилан бэлтгэсэн байлаа.

Сурталчилгааг өргөн, олон нийтийг төлөөлж чадахуйц хүрээнд зохион байгуулахыг эрмэлзсэнээс гадна янз бүрийн арга хэлбэрийг ашигласан. Юуны өмнө Улаанбаатар хотод бага хурал зохион байгуулж олон нийт, хэвлэл мэдээллийнхэн, ТББ, сурталчилгааг нутагтаа зохион байгуулах орон нутгийн төлөөлөгчдөд сурталчилгааны ажлын зорилго зорилтуудыг таниулан, мэдээлэл заавар зөвлөгөө өгч, бэлтгэсэн багц материалаар хангасан.


Сурталчилгааны ажилд 21 аймаг, 75 сум, Нийслэлийн бүх дүүрэг, зарим хороодын төлөөлөл, нийт давхардсан тоогоор 4795 хүн хамрагдсан. Сургалт семинарыг 18 удаа зохион байгуулж 495 хүн оролцсон бөгөөд семинарын явцад тухайн орон нутгийн хүний хөгжлийн байдлын талаар бүлгийн ярилцлага хийх, чөлөөт ярилцлага өрнүүлэх зэрэг хүмүүсийн идэвхтэй байдлыг ханган санал бодлыг нь авч байлаа. Яриа таниулгыг 28 удаа зохион байгуулж 1278 хүнийг хамарсан. Үүнээс гадна орон нутгийн 136 төлөвлөлтийн мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцсан. Сурталчилгаанд нийт 2019 хүнийг оролцуулснаас гадна 1879 хүнээс хүний хөгжлийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам, аймаг, сум, багийн хүний хөгжлийн түвшингийн үнэлгээ, санал асуулга авсан болно. Шилдэг нийтлэл шалгаруулах уралдаанд Улаанбаатар хот болон 13 аймгийн 695 хүүхдүүд, 14 сэтгүүлч, хэвлэн нийтлэгчид оролцлоо. Сурталчилгааг төвийн болон бүх аймгийн орон нутгийн телевиз, радио, сонин хэвлэлээр өргөн хийсэн.

Сурталчилгааны хамарсан хүрээ

Аймаг	Сум	Нийслэлийн дүүрэг	Сургалт семинарт оролцогчид	Яриа таниулгал хамрагдсан	Уулзсан төлөвлөлтийн мэргэжилтнүүд	Нийт сурталчилгаанд хамрагдсан	Санал асуулга авсан	Шилдэг нийтлэлийн уралдаанд оролцсон хүүхдүүд	Шилдэг нийтлэлийн уралдаанд оролцсон сэтгүүлчид	Бага хурал	Үр дүнгийн семинар	Бүгд (давхардсан тоогоор)
тоо	тоо	тоо	хүн	хүн	хүн	хүн	хүн	хүн	хүн	хүн	хүн	хүн
21	75	9	495	1278	136	2019	1879	695	14	110	78	4795

Сургалт семинар, яриа таниулга, санал асуулгад оролцогсдын 30.7 хувь нь 18-25 насныхан, 28.9 хувь нь 26-35 насныхан, 40.4 хувь нь 36-аас дээш насныхан байлаа. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд зонхилж 64,8 хувь, боловсролын хувьд 55,3 хувь нь дээд боловсролтой хүмүүс байсан болно.

Сургалт семинар, яриа таниулгад аймгуудын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Боловсрол, Эрүүл мэнд, Хөдөө аж ахуйн удирдах газар, эмнэлэг, сургууль, соёлын төвийн ажилтнууд, ТББ, малчид, бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийнхэн, их дээд, дунд сургуулийн багш, оюутан залуучууд зэрэг өргөн төлөөллийн хүмүүс оролцсон нь олон нийтийн санал бодлыг цаашид бодлого боловсруулагчдад хүргэх бидний зорилгод нийцэж байлаа. Нөгөө талаар Монголын 2003 оны хүний хөгжлийн илтгэл нь үнэхээр цаг үеэ олсон, нэн тулгамдсан, хүн болгоны анхаарлыг татсан чухал асуудлаар бичигдсэн нь сурталчилгааны ажлын явцад уулзсан хүмүүсийн санал сэтгэгдлээр илэрхийлэгдэж байв.



Бага хурлын явцад гарсан санал шүүмжлэл, уг хурлын салбар хуралдаануудаас дэвшүүлсэн асуудлууд, сургалт семинарын явцад зохион байгуулсан бүлгийн ярилцлага болон чөлөөт ярилцлага, төлөвлөлтийн мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын тэмдэглэл, яриа таниулга, санал асуулгын үр дүнг нэгтгэн хүний хөгжлийн түвшинг дээшлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар олон нийтийн санал бодлыг дүгнэсэн болно. Тулгамдсан асуудлыг хэлэлцэхдээ тухайн аймгийн хүний хөгжлийн нөхцөл байдал, үүнд нөлөөлж буй хүчин зүйлийг түлхүү анхааран

хэлэлцэж байсан боловч санал бодлыг нэгтгэн дүгнэхэд хэдэн асуудал дээр олон нийтийн санал бодол төвлөрсөн байлаа. Тухайлбал нэн тулгамдсан асуудлын тоонд *нэгд* ажилгүйдэл, ядуурал, *хоёрт* эрүүл мэнд, боловсрол, *гуравт* аюулгүй орчинд амьдрах боломж, *дөрөвт* төвлөрөл, *тавд* байгаль орчны тогтвортой байдал орсон байна. Судалгаанд хамрагдагсдын 31 хувь нь хүний хөгжлийн тулгамдсан асуудлыг ажилгүйдэл ядуурал, 18 хувь нь боловсролын үйлчилгээ, 18 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ, 15 хувь нь аюулгүй орчинд амьдрах боломж, 8 хувь нь төвлөрөл, 6 хувь нь байгаль орчин, 4 хувь нь бусад асуудалтай холбон тайлбарлаж байлаа. Эдгээр асуудлууд нь хөдөөгийн хүний хөгжлийн түвшин хотынхоос нилээд доогуур байх үндсэн шалтгаан болж байна.

Тулгамдсан асуудлууд (хувиар)



Засаг захиргааны нэгж жижгэрч, хүн ам цөөрч, төвөөс алслагдах тусам хүний хөгжлийн түвшин эрс буурч байна. Энэ талаар орон нутгийнхний өгсөн үнэлгээг аваад үзвэл сурталчилгаанд хамрагдсан нийт хүний 55.1хувь нь аймгийн төвийг хүний хөгжлийн түвшингээрээ дунд гэсэн үнэлгээ өгсөн байхад сумын төвийг дийлэнх нь дунд, муу, багийн төвийг дийлэнх нь муу, маш муу гэсэн үнэлгээ өгчээ. Сумын төвийн хүний хөгжлийн түвшинг маш сайн, сайн гэж үнэлсэн 7.3-хан хувь, багийн төвийг маш сайн, сайн гэж үнэлсэн 3.3-хан хувь байна.

Хүний хөгжилд нөлөөлж байгаа хамгийн тулгамдсан асуудал нь ажилгүйдэл, ядуурал бөгөөд түүнийг шийдвэрлэхийн тулд ажлын байр бий

болгох, өрхийн аж ахуйг дэмжих нь чухал байна. Өрхийн аж ахуй нь өөрийгөө авч явах хэмжээнд бага орлоготой байдаг учраас тээврийн зардал, хүүхдийн сургалтын төлбөр зэрэг амьжиргааны наад захын хэрэгцээт зардлыг татвараас чөлөөлөх нь зүйтэй гэж үзэж байлаа.

Орон нутгийн онцлог, нөөцийг түшиглэн ноос, ноолуур, арьс, шир, мах, сүү, төмс, хүнсний ногоо, жимс, үр тариа, гахай, тахиа үржүүлэх чиглэлээр ЖДҮ-ийг хөгжүүлж наад захын эрэлт хэрэгцээгээ өөрөө хангах бодлого баримтлах нь зүйтэй. Тухайлбал Хөвсгөл аймагт мал эмнэлгийн үйлчилгээ, зээлийн үйл ажиллагаа, тоосго, эсгий, үр тарианы үйлдвэрлэлийн чиглэлээр хоршоог хөгжүүлэх боломжтой, түүнчлэн фосфоритын ордыг байгаль орчиндоо халгүй технологээр ашиглах нь зүйтэй гэж нутгийн иргэд үзэж байна. Ер нь орон нутгийн онцлогийг судлаж түүнд тохирсон бизнесийн сургалт, зөвлөлгөөг зохион байгуулах, эмзэг бүлгийг амьдрах ухаанд сургах шаардлага харагдаж байна.

Хөдөөгийнхний ажилгүйдэл ядуурлыг үзэх үзэлд өөрчлөлт гарч, ядуурлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд илүү ач холбогдол өгч байна. Ажилгүйдэл ядуурлыг тооцож байгаа арга зүй боловсронгуй бишээс ядуу байх сонирхол, бэлэнчлэх сэтгэлгээг төрүүлэх, үр дүнгүй байх зэрэг дутагдал гарах болов. Ажилгүйдэл, ядууралд өртөж байгаа хүмүүсийн шалтгаан нөхцлийг судлаж, ялгавартай арга хэмжээ авах хэрэгтэй байна. Хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид ялангуяа багш, эмч нар түүнчлэн малчид, өндөр настнуудыг ядуурлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг илүү анхаарах шаардлага гарч байна. Төрийн албан хаагчид цалингаас цалингийн хооронд амьдарч чадахаа больж, банкинд цалингийн зээлийн өртэй, хүүхдийнхээ сургалтын төлбөрийн өртэй амьдардаг болсон байна. Сүүлийн жилүүдэд удаа дараа болсон байгалийн бэрхшээлд малаа алдаж малгүй болсон малчид төв суурин газар руу шилжих нь ихэсч энэ хэмжээгээрээ ядуурал, ажилгүйдлийг нэмэгдүүлж байна.

Ядуурлаас урьдчилан сэргийлэхэд орон нутгийн нөөц боломжийг дайчлах нь зүйтэй. Тухайлбал Өмнөговь аймгийн Тавантолгойн нүүрсний уурхай орон нутгийн 50 хувийн өмчтэй. Энэ орлогоос төрийн албан хаагчдад говийн нэмэгдэл олгох, сургалтын сан байгуулах зэргээр туслаж байгаа нь тэдний амьжиргаанд нөлөөлж байна гэж ярьж байв.

Хүний хөгжлийн тулгамдсан асуудлаар олон нийтийн саналыг хамгийн их авсан дараагийн асуудал нь эрүүл мэндийн үйлчилгээ байв. Энэ асуудлыг хэлэлцэх үед эмч дутагдаж байгаа, хүнсний аюулгүй байдал муу,¹ хоол тэжээлийн хомсдолтой, ундны ус эрүүл ахуйн шаардлага хангадаггүй, иргэдийн эрүүл мэндийн боловсрол муу гэсэн дүгнэлтийг бараг бүх аймгийн төлөөлөл гаргасан юм.

Хөдөөд эмчээр дутагдаж байгаа гол шалтгаан нь эмч нарын нийгмийн асуудал хүндрэлтэй байгаатай холбоотой. Одоогийн байдлаар Хөвсгөл, Булган, Хэнтий болон бусад нилээд аймгийн зарим суманд эмч дутагдалтай, Сүхбаатар, Дорноговь, Хэнтий болон бусад олон аймагт гэрээт эмч ажиллаж байна. Гэрээт эмч ажиллуулах хэлбэрийг ашиглаж байгаа ч ирж байгаа эмч нарын чадвар муу байхаас гадна гэрээ дуусаад явчихдаг болохоор үр дүн муу байна. Энэ учраас гэрээгээр эмч ажилуулахын тулд нутгийн хүнийг сургаж бэлтгэвэл тогтвор суурьшил нь дээр гэж дүгнэж байна.

Хүнсний аюулгүй байдал хангалтгүй байгаагаас элэг цөс, ходоод, хорт хавдар зэрэг өвчлөл их байгааг нийт аймгийн төлөөлөл дүгнэж байна. Хоол тэжээлийн хомсдолоос шалтгаалж цус багадах өвчин их байгаа нь эх нялхсын эндэгдэл, ялангуяа эхийн эндэгдэл буурахгүй байгаагийн гол шалтгаан болж байна. Эх нялхсын эндэгдэл голдуу хөдөө баг дээр гарч байна. Эхийн эндэгдэлд өртөж болзошгүй өрхөд эмзэг бүлгийн, боловсрол бага, олон төрсөн, архаг өвчтэй эхчүүд бүхий өрхүүд багтаж байна.

Ундны усны эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй талаар нийт аймагт яригдаж байснаас Говь-Алтай, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Сүхбаатар зэрэг говийн бүсийн аймгууд хамгийн хүндрэлтэй байна. Ундны ус хатуулагтай, эрдэс бодис ихтэй, олон жил солиогүй сувагнаас зэвтэй ус гардаг, ил задгай ус хэрэглэж байгаа зэрэг бэрхшээлүүд байгаа нь эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй байна. Хүн амын өвчлөл их түүний дотор элэг цөсний өвчин ихэсч байгаагийн нэг гол шалтгааныг ундны ус эрүүл ахуйн шаардлага хангаагүйтэй холбоотой гэж дүгнэв.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт муу, иргэдийн эрүүл мэндийн боловсрол муу байна. Хүүхдэд бүр багаас нь тухайлбал сургуулийн өмнөх наснаас нь эрүүл мэндийн боловсролыг төлөвшүүлэх, эцэг

эхчүүдэд сургалт явуулдаг байх хэрэгтэй. Эмгүй эмчилгээний арга барилд гэр бүлийг сургах, зөвлөх, хэвшүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Аймгуудын хүн амын эрүүл мэндийн түвшин, өвчлөлийн шалтгааныг судлаж тохирсон арга хэмжээг авах нь зүйтэй гэжээ.

Хүн амын шилжих хөдөлгөөн ихэсч байгаа энэ үед нийгмийн даатгалын хуулийг шилжилт хөдөлгөөнтэй холбож уян хатан, боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Шилжин ирэгсэд нь нийгмийн даатгалаа шуурхай шилжүүлж чадахгүй байгаагаас тухайн орон нутгийн эрүүл мэндийн зардал хүрдэггүй бэрхшээл бий болоод байна.

Хүний хөгжилтэй холбогдуулан боловсролын салбарт тохиолдож байгаа бэрхшээлийг хөдөөд багш дутагдалтай, сургуулиудын ачаалал жигд биш болсон, сургалтын орчин муу, сургалтын чанар муу, сургууль завсардалт тууштай буураагүй, боловсролд шинэчлэл муу хийгдэж байгаа зэрэгтэй холбон үзэж байна.

Сумдаас аймгийн төв рүү шилжих хөдөлгөөн ихэсч, аймгийн төвийн сургуулийн ачаалал нь хэт ихэдсэнээс 900 хүүхдийн багтаамжтай сургуулиуд 2000 орчим хүүхэдтэй хичээллэж байгаа нь нийтлэг үзэгдэл болжээ. Нөгөө талаас аймгийн төвийн ойролцоо сумд эзэнгүйрэх хандлагатай болж, 1000 хүрэхгүй хүнтэй, 100 хүрэхгүй сурагчтай, 6 багштай сум хүртэл байна. Хувьсах зардлаар төсвөөс санхүүжилт авдаг нь ачаалал ихэдсэн сургуулиудын хувьд нэг талаасаа хэрэгтэй мэт боловч нөгөө талаас сургалтын орчин, чанарт маш муугаар нөлөөлж байна.

Боловсролын салбарт суралцагсад болон багш нарын дийлэнх нь эмэгтэйчүүд болсон нь энэ салбарт жендерийн асуудал тулгамдаж байгааг харуулж байна. Боловсролын тулгамдсан бусад асуудалд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүртээмж муу, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн үйл ажиллагааг сэргээж орон нутгийг мэргэжилтэй, чадвартай ажилчдаар хангах асуудлуудыг онцлон сонголоо. Өмнөговь аймгийн Оюутолгойд гэхэд л Улаанбаатараас ажилчид очиж ажиллаж байна. Говийн 3 аймагт ажиллаж байгаа Шивээ овоо, Тавантолгой гэх мэт уурхайнуудыг түшиглээд МСҮТ байгуулж, орон нутгийг мэргэжилтэй ажиллах хүчнээр хангах нь зүйтэй гэж үзэж байна.

Аюулгүй орчинд амьдрах боломжид тохиолдож байгаа бэрхшээл нь хувь хүний ухамсрын доройтол, байгаль орчны бохирдол, хүнсний аюулгүй байдал, ундны ус эрүүл ахуйн шаардлага хангаагүй, ялгаварлал өссөн зэрэгтэй холбоотой байна. Архидалт, гэмт хэрэг, хүчирхийлэл, хээл хахууль, нам, нутаг ус, нас, хүйсээр ялгаварлах, ядуугаас боловсролгүй болж ялгаварлагдах явдал их болжээ. Гэмт хэргийн илрүүлэлт хөдөөд хотоос муу байна гэж үзсэн байна.

Цөлжилт явагдах нь Архангай аймгийн Тариат суманд ч эхлээд байна. Ургамал, амьтан устаж алга болох ялангуяа бэлчээрийн доройтлоос мал аж ахуйн хөгжил хязгаарлагдаж байна. Уул уурхайн үйлдвэр хөгжиж байгаа орон нутагт байгаль орчныг эвдэж сүйтгээд нөхөн сэргээх ажил хангалтгүй байна. Дотоодын жуулчид сүүлийн үед нэмэгдсэн нь орчны бохирдол их гарахад нөлөөлж байна. Орон нутагт энэ асуудлыг шийдвэрлэхэд гол бэрхшээл нь санхүүгийн асуудал байна. Байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанаас орон нутагт орох орлого дэндүү бага учраас арга хэмжээ авах боломжгүй байна. Аж ахуйн нэгжүүд өөрсдөө байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааг муу хийдгээс гадна орон нутаг түүнд хяналт тавьж хэрэгжүүлэх боломжоор муу байна. Орон нутаг өөрийн нутаг дэвсгэрээ хамгаалах, нөхөн сэргээхэд үндсэн эрх үүрэгтэй байх ёстой гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан албан татварын хууль, төсвийн тухай хууль, газрын хуулийг боловсронгуй болгож орон нутгийн удирдлагын эрх мэдлийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Тэнцвэргүй хөгжлийн улмаас шилжих хөдөлгөөн ихэсч боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хүндрэл учирч байна. Аймгийн төвүүдийн ойролцоох сумд эзгүйрч, аймгийн төвийн ачаалал ихэсчээ.

Орлогыг хэт төвлөрүүлж байгаа талаар нийт аймгуудад яригдсаны дотор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой Говьсүмбэр, Дорноговь, Өмноговь зэрэг аймгуудад илүү их яригдсан байна. Төсвийн удирдлага санхүүжилтийн шинэ хууль хэрэгжсэнээр нутгийн удирдлагын эрх мэдэл буурч салбарын удирдлага давамгайлж байна гэж дүгнэж байна. Сурталчилгааны явцад олон нийтээс гарч байсан дээрх санал бодол нь “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-т дурьдсан агуулга санаа, дэвшүүлсэн зөвлөмжийг нотлож байсан төдийгүй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг өөрийн орон нутгийн онцлогт тулгуурлан илүү тодорхой ярьж байснаараа ач холбогдолтой байв. Сурталчилгааны явцад хүний

хөгжлийн үндсэн асуудлуудаар орон нутгийнхны санал бодлыг судлаж тэднээс гарсан хүсэлтийг нэгтгэн дүгнэж холбогдох яам, бодлого боловсруулагчдад хүргэсэн юм⁴.

Ийнхүү “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-ын гол санаа, агуулга, зөвлөмжүүдийг олон нийтэд сурталчлах ажлыг ухуулан таниулах, сурталчлах, нөлөөлөх зэргээр иж бүрэн, олон нийтийг төлөөлж чадахуйц хүрээнд зохион байгууллаа. Сурталчилгаанд оролцогчид дэлхийн болон үндэсний хүний хөгжлийн илтгэлийн талаар тодорхой мэдлэгтэй болсноос гадна хүний хөгжлийн талаар цогц ойлголттой болж, өөрийн аймгийн хүний хөгжлийн түвшинд үнэлгээ дүгнэлт хийж, ярилцлага мэтгэлцээн өрнүүлж, санал бодлоо идэвхтэй илэрхийлж байсан нь хот, хөдөөгийн хүмүүсийн амьдралын чанарын ялгаатай байдал нь манай орны тулгамдсан асуудал болоод байгааг харуулж байв. Ийнхүү идэвхтэй хэлэлцүүлэг өрнөхөд “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-т хүний хөгжлийн индексийг аймгуудаар тодорхойлж эрэмбэлсэн нь орон нутгийн хүмүүсийн сэтгэхүйд их нөлөөлж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Орон нутгийнхан хүнд хүрсэн үр дүнтэй ажил боллоо гэж талархан хүлээн авч ийм ажлыг цаашид үргэлжлүүлэн явуулж байх, ингэхдээ аймгийн Засаг дарга нарын түвшинд бас зохион байгуулж байх, орон нутгийн удирдах ажилтнуудын ажлыг үнэлж дүгнэхдээ тухайн орон нутгийн хүний хөгжлийн түвшин дээшилсэн эсэх, мөн санхүүжилт, нэн ялангуяа гадаадын зээл тусламжийг хуваарилахдаа хүний хөгжлийн үзүүлэлт, индексийг харгалзаж байх нь зүйтэй гэсэн санал гаргаж байлаа. Сурталчилгааны ажил нь орон нутгийн сонгууль явагдаж байсан хугацаатай таарснаас аймгийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт хэлэлцсэн зарим асуудлыг тусгах таатай нөхцөл боломж өгсөн нь сурталчилгааны бас нэг үр дүн юм. Ийнхүү бидний хийсэн сурталчилгааны ажил нь олон нийтийн идэвх санаачлагыг өрнүүлэх, хөгжлийн төлөөх ажиллагаанд оролцох, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд нэгэн өвөрмөц туршлага боллоо.

2000 онд дэлхийн 189 орны төр засгийн тэргүүн нар хүний хөгжлийг хөхүүлэн дэмжих үндсэн цар хүрээг тодорхойлсон Мянганы Тунхаглал, Мянганы Хөгжлийн Зорилтуудыг (МХЗ) баталсан билээ. Үүнд 2015 он гэхэд бүх хүүхдэд

⁴ “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-ын сурталчилгааны үр дүн, олон нийтийн санал бодол, товхимол 2004.

бага боловсрол олгох, эх хүүхдийн эндэгдлийг бууруулах, ХДХВ/ДОХ болон бусад халдварт өвчний тархалтыг хязгаарлах, туйлын ядуурал, өлсгөлөнд өртсөн хүмүүсийн тоог хоёр дахин бууруулах зэрэг өргөн хүрээний асуудал орсон. 2005 оны 9 дүгээр сард Дэлхийн удирдагчид МХЗ-ыг хэрэгжүүлэхийн төлөө эргэж буцалтгүй санаа шулуудсанаа, мөн урьд нь НҮБ-ын бага хурлууд, Дээд хэмжээний чуулга уулзалтын үеэр тохиролцсон НҮБ-ын хөгжлийн зорилго, өргөн цар хүрээтэй асуудлаар санал нэгтэй байгаагаа илэрхийлэхээр дахин хуран чуулж 2006 он гэхэд хөгжлийн эдгээр зорилтуудад хүрэхэд чиглэсэн үндэсний хөгжлийн стратегиа батлахаар тохиролцсон.

УИХ-ын 2005 оны намрын Чуулганы нээлт дээр Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулахдаа хүний хөгжлийн асуудлыг голлон анхаарахын чухлыг дурьдав. 2005 оны Дэлхийн хүний хөгжлийн илтгэлд манай Монгол улс МХЗ-ыг хэрэгжүүлж байгаа орны тоонд орсон боловч энд тунгаан шийдвэрлэх асуудал нилээд байгааг хүний хөгжлийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар олон нийтээс дэвшүүлсэн санал бодол нотолж байна. Иймд хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлалыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.3	2.3	2.3	2.3	2.3
2.0	2.0	2.0	2.0	2.0
0.7	0.7	0.7	0.7	0.7
0.3	0.3	0.3	0.3	0.3
0.2	0.2	0.2	0.2	0.2
0.1	0.1	0.1	0.1	0.1
0.0	0.0	0.0	0.0	0.0
0.0	0.0	0.0	0.0	0.0
0.0	0.0	0.0	0.0	0.0
0.0	0.0	0.0	0.0	0.0